

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2019 санхүүгийн тайланд хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 441 тоот тогтоол, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 2019 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланд тусгагдсан хуримтлагдсан ашгийн дүнгээр буюу 269,907,162 /Хоёр зуун жаран есөн сая есөн зуун долоон мянга нэг зуун жаран хоёр/ төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.
2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2022 оны 02 сарын 10 өдрөөс өмнө 2,5 тэрбум төгрөг болгосугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай

Монгол Улсын банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйл, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус нэмж авсугай.
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Бизнес төлөвлөгөөг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журмыг Хавсралт №2-оор, Факторингийн үйлчилгээний журмыг Хавсралт №3-аар, Төлбөрийн баталгааны журмыг Хавсралт №4-өөр тус тус баталсугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Салбар нэгж байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, зах зээлээ тэлэх бодлогын хүрээнд зээлийн үйл ажиллагаа явуулах салбар нэгжийг Улаанбаатар хотод байгуулсугай.
5. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн салбарын үйл ажиллагаанд мөрдөх журмыг Хавсралт №1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Компанийн нэмэлт энгийн хувьцаа гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дэх заалт, ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зах зээлээ тэлэх бодлогын хүрээнд 8,5 тэрбум төгрөгөөс доошгүй хөрөнгийг хөрөнгийн зах зээлээс энгийн хувьцаагаар татан төвлөрүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн нэмэлт энгийн хувьцаа гаргах нөхцөлийг Хавсралт №1 -ээр баталсугай.
3. Нэмж гаргаж буй энгийн хувьцааны нийтэд санал болгох үнэ, тоо ширхэг, нэмж гаргах энгийн хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор нэмэлт энгийн хувьцаатай хамааралтай бүртгэлийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн
6 тоот тогтоолын Хавсралт №1

1. Хаалттай хүрээнд нэмэлт энгийн хувьцаа гаргах тооцоолол

Нийт гаргасан хувьцаа	996,133,950
Нэмж гаргах хувьцаа	426,914,550
Нийт гаргасны дараах хувьцаа	1,423,048,500
Нэмж гаргаж буй хувь	30%
Татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ	8,500,000,000

2. Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Зээлийн багц нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн гаргах	80%
Нэмж салбар нэгж байгуулах	5%
Боловсон хүчин нэмэгдүүлэх	5%
IT хөгжүүлэлт	10%

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Өрийн бичиг гаргах тухай

Монгол Улсын Үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хаалттай хүрээнд өөрийн хөрөнгийн 50 хувь хүртэлх өрийн хэрэгсэл гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Өрийн бичиг гаргахтай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хаалттай хүрээнд санал болгож буй өрийн хэрэгсэлтэй хамааралтай бүртгэлийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай



ХУРЛЫН ДАРГА

 Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн
08 тоот тогтоолын Хавсралт №1

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн дүрэмд орох өөрчлөлтүүд:

Харьцуулалтууд		
Шинэчилсэн	Хуучин	Тэмдэглэл
3.1.4 “Итгэлцлийн үйлчилгээ”		Нэмсэн
3.1.5 “Факторингийн үйлчилгээ”		Нэмсэн
3.1.6 “Төлбөрийн баталгаа гаргах”		Нэмсэн
6.1 “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2,262,175,062 /Хоёр тэрбум хоёр зуун жаран хоёр сая нэг зуун далан таван мянга жаран хоёр/-н төгрөг байна.	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,992,267,900 /Нэг тэрбум есөн зуун ерэн хоёр сая хоёр зуун жаран долоон мянга есөн зуун/ төгрөг байна.	Шинэчилсэн
6.9 Эзэмшлийн хувь харуулсан хүснэгт	Компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшлийн байдал доорх байдалтай байна.	Хассан
9.2.13 “ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно”	ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.	Шинэчилсэн

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 21 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны зардлын төсвийг Хавсралт №1-р баталсугай.
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг Хавсралт №2-р баталсугай.
3. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн
09 тоот тогтоолын Хавсралт №1

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны төсөв

№	Үзүүлэлт	Жил
1	Боловсон хүчний холбогдолтой зардал	159,000,000.00
2	Зээл болон авлага барагдуулахтай холбоотой	2,000,000.00
3	Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	25,000,000.00
4	Түрээс	36,000,000.00
5	Үндсэн хөрөнгийн элэгдэл	6,000,000.00
6	Харуул хамгаалалт	1,400,000.00
7	Харилцаа холбоо, интернэт	2,300,000.00
8	Тээврийн зардал	10,000,000.00
9	Зохицуулалтын хураамж	4,000,000.00
10	Автомжуулалттай холбоотой зардал	2,000,000.00
11	Зар сурталчилгаа маркетинг	15,000,000.00
12	Бичиг хэрэг	2,000,000.00
13	Ариун цэвэр	1,000,000.00
14	Харилцагчдын сургалт судалгаа	10,000,000.00
15	Зээлийн эрсдэлийн зардал	50,000,000.00
16	Зочин төлөөлөгчийн зардал	15,000,000.00
17	Албан томилолт	20,000,000.00
17	Баяр ёслол	2,000,000.00
Нийт дүн		362,700,000.00



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн
09 тоот тогтоолын Хавсралт №2

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Цалин /дарга/	1	580,000	6,960,000
2	Цалин /гишүүд/	8	420,000	40,320,000
3	ТУЗ-н бичиг хэрэг	1		500,000
4	ТУЗ-ын томилолт			15,000,000
Нийт дүн				62,780,000